



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 414

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтгүй байгаа 48,470,000.00 (дөчин найман сая дөрвөн зуун далан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Улсын нэгдүгээр төв эмнэлэгт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Л.Насанцэнгэл, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Чулуунбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн  
~~14~~ дугаар тогтоолын хавсралт



СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГТ  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

| Д/д | Хөрөнгийн нэр          | Ашиглал-<br>тад орсон<br>он | Тоо<br>хэмжээ | Нэг бүрийн үнэ<br>(төгрөг)                                                | Балансын үнэ<br>(төгрөг)                                                  |
|-----|------------------------|-----------------------------|---------------|---------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|
| 1   | Угаалгын автомат машин | 2018                        | 1             | 48,470,000.00                                                             | 48,470,000.00                                                             |
|     | Дүн                    | -                           | 1             | <b>48,470,000.00</b><br>(дөчин найман<br>сая дөрвөн зуун<br>далан мянган) | <b>48,470,000.00</b><br>(дөчин найман<br>сая дөрвөн зуун<br>далан мянган) |